



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/55

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шунхлай 5 дугаар багийн нутагт “Төвийн усан хангамжийн нэгдсэн системийн байгууламж”-ийг усны эх үүсвэрээр хангах 2 гүний худаг барих зориулалтаар худаг тус бүрт 0,25 га газар, усан сан барих зориулалтаар 0,2 га газар, цэвэр ус дамжуулах гол шугам болон хуваарилах шугамын трассын эргэлтийн цэгүүдийн координатын дагуу цэвэр ус дамжуулах шугамаас хоёр тийш 5 метрийн өргөнтэй 11 га газрыг шугамын хамгаалалтын бүсийн зориулалтаар тус тус Засаг даргын Тамгын газар (9045562) –т 60 жилийн хугацаатайгаар хавсралт зургын дагуу эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшүүлэхтэй холбогдсон бичиг баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж, газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд заагдсан зориулалтын дагуу зүй зохистой ашиглахыг Засаг даргын Тамгын газарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

620100109